

# БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сарын 15

Улаанбаатар хот

“Барилга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг /цаашид ХЭХ гэх/ 2026 оны 04 сарын 15-ны өдрийн 09:00 цагаас танхимаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурлын ирц танилцуулснаар 09:00 цагт 40075 хувьцаа эзэмшдэг гишүүд оролцсоноор 98,65 хувийн ирцтэй эхлэв. Хуралд хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцов.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга Ш.Эрдэнэбат нээж хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, ТУЗ-өөс гаргасан тогтоолын төсөл, хурлын дэгийг танилцуулав. Хурлын дэгийг 100 хувийн санал нэгдэж батлав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэргүүлэгчээр Ш.Эрдэнэбат, Г.Идэр, Н.Одонтуяа нарыг томилов. Мөн тооллогын комиссыг Э.Батсүх, Б.Хүрлээ, Н.Одонтуяа нарын бүрэлдэхүүнтэй сонгож томилов.

Хэлэлцэх асуудлууд:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн /ТУЗ/ тайлан, дүгнэлт – 10 минут  
-“Барилга” ХК-ийн ТУЗ-ын дарга Ш.Эрдэнэбат
2. Компанийн 2025 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан, гэрээт аудитын тайлан, дүгнэлт – 8 минут  
-“Барилга” ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч Э.Батсүх
3. Компанийн 2026 оны үйл ажиллагааны чиглэл, 2025 оны үр дүнгийн болон ногдол ашиг хуваарилах тухай – 10 минут  
“Барилга” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат
4. Асуулт, хариулт хүн тус бүр 3 минут
5. Үг хэлэх, санал шүүмжлэл хүн тус бүр 5 минут
6. Хурлаас гарах шийдвэрийн төсөл хэлэлцэхэд цаг тогтоохгүй

Хуралд оролцогсод тухай бүрт нь асуулт хариулт, санал шүүмжлэлүүдийг хэлэлцэхээр тогтов.

“Барилга” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ш.Эрдэнэбат ТУЗ-ийн 2025 оны тайланг уншиж танилцуулав. ТУЗ-ийн даргын 2025 оны тайланг хавсаргав

Үүний дараа Ерөнхий нягтлан бодогч Э.Батсүх 2025 оны санхүүгийн тайлан болон санхүүгийн зохицуулах хорооны тусгай эрх бүхий “Дундманхайдай” ХХК-ийн аудитын дүгнэлтийг болон аудиторос өгөгдсөн зааварчилгаа, зөвлөмжүүдийг уншиж танилцуулав. Мөн өгөгдсөн зааварчилгаа зөвлөмжүүдийн дагуу өгөгдсөн хариулт, тайлбаруудыг танилцуулав. 2025 санхүүгийн тайланг болон аудитын дүгнэлтийг хавсаргав.

“Барилга” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат өнгөрсөн 2025 оны байгууллагын тайлан, үйл ажиллагааны үр дүн болон ирэх оны үйл ажиллагааны чиглэлийн талаархи тайлангаа уншиж танилцуулав. Нэмэлтээр үр дүнгийн тухай танилцуулга хийв. Гүйцэтгэх захирлын 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хавсаргасан болно.

## БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

**Ш.Эрдэнэбат:** Үндсэн 3 тайлантай холбогдолтой санал, асуулт байна уу?

**Г.Идэр:** Санхүүгийн тайлан дээр 2025 онд гүйцэтгэл бага мөртлөө НД-ын шимтгэл өссөн байна. Үүнийг тодруулж өгөөч.

**Э.Батсүх:** НД-ын Ерөнхий газрын тушаалаар цалингаас суутгах шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдсэн мөн цалингийн шатлал, цалингийн доод хэмжээ нэмэгдсэн зэргээс болж өссөн юм.

**Г.Идэр:** 2024 оны ЭМД, НД-ын шимтгэлээс 2025 оны ЭМД, НД-ын шимтгэл зөрүүтэй, бага байна.

**Э.Батсүх:** 2024 онд орлого, гүйцэтгэл өндөр байсан. 2025 оны төлөвлөгөөнд багаар тавигдсан учир шимтгэл буурсан харагдаж байна.

**Ш.Эрдэнэбат:** Улсад өглөг байгаа юу?

**Э.Батсүх:** Нилээд их хэмжээний хуримтлагдсан татвар, НДШ-ийн өр байгаа.

**Ш.Эрдэнэбат:** ОТ-с орж ирж байгаа санхүүжилттэй холбоотой өр төлбөр байна уу?

**Э.Батсүх:** Тиймээ, ОТ-с 3,8 тэрбум төгрөгийн нэмэлт ажлын хугацаа сунасантай холбоотой санхүүжилт хүлээгдэж өр үүссэн байгаа.

**Ш.Эрдэнэбат:** Өөр асуух асуулт байхгүй бол санал сонсоё.

**С.Тунгалаг:** Тайлангууд сонслоо. Сайн ажилласан гэж дүгнэж байна. 2026 ондоо илүү сайн ажиллаж, том төслүүдэд хөрөнгө оруулна гэдэгт итгэж байна.

**С.Тунгалаг:** Монголын ажиллах хүч цалингаас хамаарч гадагшаа их гарч байгаа. Үндсэн ажиллах хүчээ барууны орон шиг мэргэжилтэй, мастер ажилтнууд бэлтгэж, тогтвортой ажиллах суурийг нь хангаж, цалинг нь өгч чаддаг, өөрийн мастер ажилтнуудыг бэлтгэх хэрэгтэй.

**Э.Буянбаатар:** Тайлантай танилцлаа. Хүний нөөцийн хувьд ОТ төсөл дээр ажиллаж байгаа ажилтнууд болон компанийн хөгжил, бизнест хувь нэмэр оруулахаар үйлдвэрлэл юм уу бизнесийн салбартай болбол ажилтнууддаа тасралтгүй, тогтвортой ажиллах бололцоог хангах үүднээс тооцож, төлөвлөгөөндөө оруулах хэрэгтэй.

**Г.Идэр:** Тайлангууд, үзүүлэлт баланс тааруу байна. Компани өөрөө урт удаан хугацаанд тогтох үндэс бол мэргэжилтэй ажилтан юм. Тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангах, итгэл үнэмшлийг төрүүлэх арга бол хувьцаа эзэмшүүлэх явдал юм. ОУ-ын жишиг байдаг. Хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр байдаг. Судлаж үзээрэй.

**С.Тунгалаг:** Хүндрэлтэй нөхцөлд сайн ажилласан байна. Олон хүнийг ажлын байраар хангаж ажиллаж байгаа нь сайшаалтай. Өөрийн олон ажилтнуудыг мэргэшүүлэхийн тулд сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах, мэргэжил ахиулах, дэргэдээ сургалтын баазтай болж ажиллах нь зүйтэй юм.

## БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Ш.Эрдэнэбат: Санал хэлсэн та бүхэндээ баярлалаа. Санал хэлэлцэж дууссан тул одоо Тооллогын комиссын санал хураая. /Тарааж өгсөн саналын хуудсуудыг хурааж авав/

3-р тогтоолын төсөл уншиж танилцуулав. Тогтоол №3-г 100 хувь саналаар батлав.

Ш.Эрдэнэбат: 4, 5, 6 тогтоолуудын төсөл уншиж танилцуулав.

Тогтоол тус бүрийг 100%-ийн санал нэгтэй дэмжиж батлав.

Мөн Тогтоол №7 “2026 оны үндсэн үзүүлэлтийг батлах тухай”, Тогтоол №8 “Ногдол ашгийн хуваарилалтын тухай”, Тогтоол №9 “Компанийн удирдлагыг сонгох тухай”, Тогтоол №10 “Компанид хувьцаа худалдан авах тухай” 100%-ын саналтай дэмжиж батлав.

Өөр санал гарсангүй, хурал 11:00 цагт дуусав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ш.ЭРДЭНЭБАТ

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.АРИУНТУЯА

